



**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САЛБАРТ
ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ, ТАЙЛАНДЫН ВАНТ УЛСЫН ШИНЖЛЭХ
УХААН, ТЕХНОЛОГИЙН ЯАМ ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам болон Тайландын
Вант Улсын Шинжлэх ухаан, технологийн яам (цаашид "Талууд" гэх)

Хоёр орны найрсаг харилцааг цаашид хөгжүүлэхийг эрмэлзэн;

Эрдэм шинжилгээний судалгаа болон технологийг дэмжих нийтлэг
сонирхолыг харгалзан;

Эдгээр салбарт хоёр Тал нягт хамтран ажиллах нь ашиг тусаа ёгне
гэдгийг хүлээн зөвшөөрч;

дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Талууд хоёр орны шинжлэх ухаан, технологийн салбарын хамтын
ажиллагааны зорилго нь мэдээлэл, мэдлэг солилцох нэмэлт бололцоог
бүрдүүлэх болон хоёр Талын харилцан сонирхсон асуудлаар хамтарч
ажиллах явдал гэж тэмдэглэв.

2 дугаар зүйл

Талууд хоёр орны шинжлэх ухаан, технологийн салбарын хамтын
ажиллагаанд хүнс, биотехнологи, электроник, мэдээлэл зүй, инноваци,
анаагаах ухааныг тэргүүлэх чиглэл гэж үзэв.

Талууд шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагаанд дараах
хэлбэрээр хамтарч ажиллахаар тохиролцов. Үүнд:

- Шинжлэх ухааны парктай холбоотой мэдээлэл солилцох,
- Залуу судлаач, эрдэмтэдийг харилцан солилцох,
- Хамтарсан семинар, зөвлөгөөн зохион байгуулах, неге Талын
зохион байгуулж буй эрдэм шинжилгээний хурал, чуулган,
семинар, симпозиумд оролцуулахыг дэмжих,
- Инновацийн бүтээлээр үзэсгэлэн гаргах,
- Суурь болон хавсарга шинжлэх ухааны салбарт эрдэм
шинжилгээний хамтарсан төсөл хэрэгжүүлэх,
- Судалгааны хамтарсан лаборатори, нэгж байгуулах,
- Талуудын харилцан тохиролцох бусад хэлбэрийн хамтын
ажиллагаа.

3 дугаар зүйл

Талууд хоёр орны шинжлэх ухаан, технологийн судалгааны улсын болон хувийн байгууллага, их сургууль, эрдэм шинжилгээний төвийн хооронд шууд харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхийг хөхиүлэн дэмжиж тус дэхем үзүүлнэ.

4 дүгээр зүйл

Талууд их сургуулийн үйлдвэрлэлийн технологийн судалгаа явуулах чадавхийг дээшлүүлэхэд хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлнэ.

5 дугаар зүйл

Энэ хэлэлцээрийн дагуу мэргэжилтэн, эрдэмтэн, судлаач солилцох зардлыг дараах байдлаар шийдвэрлэнэ:

- Илгээгч тал хоёр орны нийслэл хооронд зорчих хоёр талын замын зардлыг хариуцна.
- Хүлээн авагч тал, эсхүл хамтран ажиллаж байгаа байгууллага өөрийн орны дотор зорчих замын болон байрны зардлыг хариуцна.

6 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрт дурдсан хамтын үйл ажиллагаа нь тус хоёр улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу болон харилцан тохиролцсон хөтөлбөрийн хүрээд явагдана. Хамтын ажиллагааг хоёр талын хөрөнгийн бололцоонд тулгуурлан хийж гүйцэтгэнэ.

7 дугаар зүйл

Талууд энэхүү хэлэлцээрийн хүрээнд буюу түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний явцад бий болсон оюуны өмчийг зохистой найдвартай хамгаална.

Уг хэлэлцээрийн хүрээнд үүсэх оюуны өмчийн маргааныг Талуудын оролцогч байгууллагууд зөвлөлдөх замаар шийдвэрлэнэ.

8 дугаар зүйл

1. Энэхүү хэлэлцээр нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү хэлэлцээр нь таван (5) жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх ба цаашид таван (5) жилийн хугацаагаар өөрөө аяндаа сунгагдана. Талууд энэхүү хэлэлцээрийг хүчингүй болгох тухай түүний үйлчлэх хугацаа дуусахаас зургаан (6) сарын өмнө негее Талд дипломат шугамаар бичгээр мэдэгдэж хүчингүй болгож болно. Энэхүү хэлэлцээрийг хүчингүй болгох нь уг хэлэлцээрийн дагуу хэрэгжилтийн шатандаа яваа, цаашид үргэлжлэх тесэл, хөтөлбөр болон аливаа үйл ажиллагаа дуусах хүртэл түүнд саад болохгүй.

3. Талууд ноот солилцох замаар бичгээр харилцан тохиролцсоны үндсэн дээр уг хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлт энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хүчин төгөлдөр болно.

Энэхүү хэлэлцээрийг 2013 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Улаанбаатар хотноо монгол, тай, англи хэлээр тус бүр гурван эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэр нь адил хүчинтэй байна. Тайлбарлахтай холбогдон зөрүү гарах тохиолдолд англи хэлээрх эх хувийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ

ТАЙЛАНДЫН ВАНТ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААН,
ТЕХНОЛОГИЙН ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ

Лувсанням ГАНТӨМӨР
МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙД

Ворават АУФИНЮКУЛ
ТАЙЛАНДЫН ВАНТ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААН,
ТЕХНОЛОГИЙН САЙД